ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Чулуут ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код**: АРА-2022/227/НА-СТА-ОНА

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>Чулуут сум<br>2022 он | Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-ийн<br>Ерөнхий захирал: Д.Түмэнжаргал<br>Утас: 70005329 Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com<br>Аудитын менежер: Н.Алтанзул<br>Утас: 70005329 Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com<br>Аудитор: А.Жамъян<br>Утас: 70005329 Цахим хаяг:mbr.audit.llc@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.Аудитын санал дүгнэлт ....2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан ....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .... 4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .... 5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .... 7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл... **Error! Bookmark not defined.**
3. Аудитын тайлан....9
3.1 Ерөнхий зүйл....9
3.2 Дотоод хяналт....9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....9
3.4 Материаллаг байдал ....9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга ....10
4.1 Байгууллагын үйл ажилагаа.... 10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.... 10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .... 10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....11
5.1 Шилэн дансны мэдээлэл....11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал ....12
8. Аудитын илрүүлэлт ....12
8.1 Залруулсан алдаа .... **Error! Bookmark not defined.**
8.2 Төлбөрийн акт.... **Error! Bookmark not defined.**
8.3 Албан шаардлага .... **Error! Bookmark not defined.**
8.4 Зөвлөмж.... 12
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....0

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| ААНОАТ | Аж Ахуй Нэгжийн Орлогын Албан Татвар |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |

## 1.Аудитын санал дүгнэлт

“ЧУЛУУТ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”
ОНӨААТҮГ-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ч.ЧИМЭДДЭЛЭГ ТАНАА

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чулуут ахуйн үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Чулуут Ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

**Бусад асуудал**

Архангай аймгийн Чулуут Ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ тайлант онд 13 зорилтын хүрээнд  11 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлийг 84.6 хувьтай гэж тайлагнасан байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,377,127.00** | **5,527,224.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **9,327.00** | **9,424.00** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **9,327.00** | **9,424.00** |
| **31210** | **Төгрөг** | **9,327.00** | **9,424.00** |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 9,327.00 | 9,424.00 |
| **33** | **АВЛАГА** | **1,704,100.00** | **2,954,600.00** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 1,704,100.00 | 2,954,600.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **1,663,700.00** | **2,563,200.00** |
| **35400** | **Хангамжийн материал** | **1,663,700.00** | **2,563,200.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 10,000.00 | - |
| 35420 | Аж ахуйн материал | 334,200.00 | 763,200.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,319,500.00 | 1,800,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,154,770,801.00** | **1,132,642,865.33** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,154,770,801.00** | **1,132,642,865.33** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,154,770,801.00** | **1,132,642,865.33** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,261,748,800.00 | 1,261,748,800.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (126,174,800.00) | (147,203,946.67) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 21,120,890.00 | 21,120,890.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,924,089.00) | (4,036,178.00) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | 1,013,300.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,158,147,928.00** | **1,138,170,089.33** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **6,759,109.00** | **10,424,864.44** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **6,759,109.00** | **10,424,864.44** |
| **41300** | **Өглөг** | **6,759,109.00** | **10,424,864.44** |
| **41360** | **Бусад өглөг** | **6,759,109.00** | **10,424,864.44** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 4,530,000.00 | 5,080,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 240,000.00 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 556,309.00 | 1,133,110.00 |
| 41364 | НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | 1,672,800.00 | 3,971,754.44 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,151,388,819.00** | **1,127,745,224.89** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,151,388,819.00** | **1,127,745,224.89** |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 1,261,748,800.00 | 1,261,748,800.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 19,240,890.00 | 19,240,890.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **(129,600,871.00)** | **(153,244,465.11)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (105,145,700.00) | (129,600,871.00) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (24,455,171.00) | (23,643,594.11) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,158,147,928.00** | **1,138,170,089.33** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **38,609,570.00** | **35,178,900.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **38,609,570.00** | |
| **110** | **Орлогын албан татвар** | **38,609,570.00** | |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | **38,609,570.00** | |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 38,609,570.00 | |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **35,178,900.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **-** | **35,178,900.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **-** | **5,524,900.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 5,524,900.00 |
| 120005 | Түрээсийн орлого | - | 29,654,000.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **63,064,741.00** | **58,822,494.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **63,064,741.00** | **58,822,494.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **63,064,741.00** | **58,822,494.11** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **21,757,200.00** | **24,090,000.00** |
| 210101 | Үндсэн цалин | 21,757,200.00 | 24,090,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,687,400.00** | **2,783,850.44** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,687,400.00 | 2,783,850.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **14,639,452.00** | **5,645,172.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,865,762.00 | 725,672.00 |
| 210302 | Түлш, халаалт | 4,480,500.00 | 4,919,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,293,190.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **631,600.00** | **1,525,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 64,000.00 | 10,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 1,095,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 567,600.00 | 420,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,325,100.00** | **926,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,325,100.00 | 926,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **70,800.00** | **711,236.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 400,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 20,860.00 |
| 210813 | Бусад зардал /ТӨҮГ/ | 70,800.00 | 290,376.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **22,953,189.00** | **23,141,235.67** |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 22,953,189.00 | 23,141,235.67 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(24,455,171.00)** | **(23,643,594.11)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(24,455,171.00)** | **(23,643,594.11)** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | - | (105,145,700.00) | (105,145,700.00) |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | (105,145,700.00) | (105,145,700.00) |
| 4 | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | - | - | - |
| 5 | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | 1,280,989,690.00 | - | 1,280,989,690.00 |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | - | (24,455,171.00) | (24,455,171.00) |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,280,989,690.00 | (129,600,871.00) | 1,151,388,819.00 |
| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,280,989,690.00 | (129,600,871.00) | 1,151,388,819.00 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 1,280,989,690.00 | (129,600,871.00) | 1,151,388,819.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | (23,643,594.11) | (23,643,594.11) |
| 20 | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | 1,280,989,690.00 | (153,244,465.11) | 1,127,745,224.89 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **38,609,570.00** | **33,863,400.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **38,609,570.00** | **-** |
| **110** | **Орлогын албан татвар** | **38,609,570.00** | **-** |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | **38,609,570.00** | **-** |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 38,609,570.00 | - |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **33,863,400.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **-** | **33,863,400.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **-** | **5,524,900.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 5,524,900.00 |
| 120005 | Түрээсийн орлого | - | 28,098,500.00 |
| 120009 | Бусад орлого | - | 240,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **34,592,342.00** | **32,850,003.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **34,592,342.00** | **32,850,003.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **34,592,342.00** | **32,850,003.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **20,702,180.00** | **20,979,596.00** |
| 210101 | Үндсэн цалин | 20,702,180.00 | 20,979,596.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,350,000.00** | **3,488,875.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,350,000.00 | 3,488,875.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **9,802,762.00** | **5,395,672.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,352,762.00 | 725,672.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,450,000.00 | 4,670,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,747,300.00** | **1,944,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 200,800.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 443,500.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 513,000.00 | 1,095,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 590,000.00 | 849,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **990,100.00** | **621,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 185,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 805,100.00 | 621,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **-** | **420,860.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 400,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 20,860.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **4,017,228.00** | **1,013,397.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **1,700,000.00** | **1,013,300.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,700,000.00** | **1,013,300.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **1,700,000.00** | **1,013,300.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,700,000.00 | 1,013,300.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(1,700,000.00)** | **(1,013,300.00)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **(2,307,901.00)** | **-** |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **2,307,901.00** | **-** |
| 250006 | Бусад зардал | 2,307,901.00 | - |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **9,327.00** | **97.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 9,327.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 9,327.00 | 9,424.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Чулуут Ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад НӨАТ-ын тайлангийн зөрүү, төсвийн зарцуулалт, худалдан авалт, өртөг зардал болон бусад хууль тогтоомжтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 25-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Монголиан бизнес рейтинг аудит ХХК-ийн аудитор А.Жамъян, туслах аудитор Г.Буянбадрах нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Н.Алтанзул, ерөнхий захирал Д.Түмэнжаргал нар хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Чулуут Ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ -ийн 2021 оны санхүүгийн тайланг Архангай аймаг дахь Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус байгууллага дотоод хяналтын журам, заавар боловсруулж, баталгаажуулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Чулуут ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 38.6 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 0.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Архангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 37 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна.

Компанийн удирдлага Ч.Чимэддэлэгийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсон байна.

**Чулуут-Ахуй үйлчилгээний төв”-**ийн зорилго нь Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг хямд үнээр худалдан борлуулах, ажлын байр нэмэгдүүлэхэд оршино. Тус байгууллага нь бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Өмчийн 100 хувийг төрийн өмч эзэмшиж байна.

### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Архангай аймгийн Чулуут Ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 9.4 | 9.4 | 0.1 |
| Авлага | 1.7 | 2.9 | 1.2 |
| Бараа материал | 1.6 | 2.5 | 0.9 |
| Үндсэн хөрөнгө | 1,154.7 | 1,132.6 | 20.1 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **1,158.1** | **1,138.2** | **19.9** |
| Өр төлбөрийн дүн | 6.7 | 10.4 | 3.6 |
| Богино хугацаат өглөг | 6.7 | 10.4 | 3.6 |
| Эздийн өмч | | | |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,158.1** | **1,138.2** | **19.9** |

Тайлант онд арилжааны банкны 1 харилцах дансанд 9.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд 2021 хүрээнд үүссэн 1.2 сая төгрөгөөр өссөн нь төлбөрт үйлчилгээний авлага өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 2.9 сая төгрөгийн авлага, хугацаа хэтэрсэн найдваргүй авлага байхгүй байна.

Нийт авлага 1.2 сая төгрөгөөр өсөж 3.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Төлбөрт үйлчилгээний авлага 1.2 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2.6 сая төгрөг болж, 0.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан 6.5 сая төгрөгийн түлш, шатах тослох материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө тайлант онд 1,138.3 сая төгрөг болж 20.1 сая төгрөгөөр буурсан нь худалдан авсан 1.0 сая, тайлант онд байгуулсан элэгдлийн зардал 23.1 сая төгрөгөөс шалтгаалжээ. Тайлант онд акталсан хөрөнгө байхгүй.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд бэлтгэн нийлүүлэгчид өгөх 5.1 сая, хувь хүмүүст төлөх 0.2 сая, татварын өглөг 5.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Эздийн өмчийн дүн 1,127.7 сая болж, өмнөх оноос 23.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 23.6 сая төгрөгөөс шалтгаалжээ.

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай аймгийн Чулуут Ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 12 мэдээллийг ил тод хугацаанд нь байршуулж, 34 мэдээллийг хугацаа хоцроон оруулж, 127 мэдээллийг огт мэдээллээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог нэмэгдүүлэлгүй ажилласан байна. Удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан 0.6 сая төгрөгөөр тогтоосон байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын холбогдох заалтуудтай нийцэж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 3 алдаа зөрчил илрүүлэн давтан гаргахгүй байх зөвлөмжүүдийг хүргүүлсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, кассаар гаргасан орлого, зарлагыг тулган баталгаажуулах зэргийг тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах 1 албан шаардлага, дотоод хяналттай холбоотой зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

### 8.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Дотоод хяналттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1.5 “Энэхүү журмын 1.4 д зааснаас бусад тохиолдолд Дотоод хяналтыг зохион байгуулах журмыг тухайн байгууллага аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Чулуут Ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ | АРА-2022/227/НА-СТА-ОНА | Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байна. | - | 1 | - | | | | | | | | | 1 | - |
| **ДҮН** | | | | **-** | | | | | | | | | | | **1** | - |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Чулуут Ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ | АРА-2022/227/НА-СТА-ОНА | Тайлант онд нийт 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 12 мэдээллийг ил тод хугацаанд нь байршуулж, 34 мэдээллийг хугацаа хоцроон оруулж, 127 мэдээллийг огт мэдээллээгүй байна. | | 1 | - | | | | | 1 | | | | | |
| | **ДҮН** | | | **-** | **2** | **-** | | | | | **1** | | | | **1** | |
| **НИЙТ ДҮН** | | | | **-** | **2** | **-** | | | | | **1** | | | | **1** | |